



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/131

Арвайхээр сум

“Монгол цэргийн өдөр”, Зэвсэгт хүчний 103 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.10 дахь хэсэг, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.1.5, дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Монгол цэргийн өдөр”, Зэвсэгт хүчний 103 жилийн ой, Халхын голын байлдааны ялалтын 85 жилийн түүхт ойг тохиолдуулан Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг иргэдэд сурталчлах, хүүхэд залуучууд, өсвөр үеийнхэнд цэрэг-эх оронч үзэл хүмүүжлийг төлөвшүүлэх, цэргийн хөдөлмөрийн үнэ цэн, цэргийн гэрээт болон хугацаат алба хаахын ач холбогдол, давуу талыг таниулан мэдрүүлэх, Зэвсэгт хүчний анги салбарууд, Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх арга хэмжээг зохион байгуулах ажилд шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

2.Дээрх арга хэмжээнд шаардагдах 8,738,200 (найман сая долоон зуун гучин найман мянга хоёр зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (О.Сумъяасүрэн)-д, “Монгол цэргийн өдөр”, зэвсэгт хүчний 103 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цэргийн штаб (Дэд хурандаа А.Нямхүү)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0366